

Засгийн газрын Хэрэг эрхлэх  
газрын даргын 2021 оны 3/ дугаар  
тушаалын 9/ дүгээр хавсралт



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

## ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2021-2024 ОН)

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА



Х.БАТЖАРГАЛ

Улаанбаатар хот

## ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

Нэг.Нийтлэг үндэслэл .....	4
Хоёр.Мандатын шинжилгээ .....	4
Гурав.Орчны шинжилгээ .....	8
Дөрөв.Алсын хараа .....	10
Тав.Эрхэм зорилго .....	10
Зургаа.Стратегийн зорилт .....	10
Долоо.Стратегийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам .....	11

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай тэмцэх газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
СоЯ	Соёлын яам
СЯ	Сангийн яам
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТТХГ	Төрийн тусгай хамгаалалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЭЗУС	Техник эдийн засгийн урьдчилсан судалгаа
УА	Удирдлагын академи
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

## НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Үндэсний хөгжлийн газрын стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хуулийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримтлан боловсруулсан.

Тус стратеги төлөвлөгөөг Үндэсний хөгжлийн газрын ерөнхий чиг үүрэг болох хөгжлийн бодлого, төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлох, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалт, бүртгэлийн асуудлыг хариуцан гүйцэтгэх, тэдгээрийн хэрэгжилтийг хангах харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу нэгдмэл, цогц, харилцан уялдаатай зохион байгуулах хэрэгцээ, шаардлагын хүрээнд боловсруулав.

## ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Үндэсний хөгжлийн газарт хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд Мандатын шинжилгээг хийж, дор дурдсан хүснэгтээр тодорхойлов.

Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		17	
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	1	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
		2	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
		3	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
		4	Хөрөнгө оруулалтын тухай хууль
		5	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль
		6	Төсвийн тухай хууль 12 <sup>1</sup> дүгээр зүйл
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	1	Төрийн албаны тухай хууль
		2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
		3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
		4	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
		5	Шилэн дансны тухай хууль
		6	Хөдөлмөрийн тухай хууль
		7	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
		8	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
		9	Авлигын эсрэг хууль
		10	Захиргааны ерөнхий хууль
		11	Холбогдох бусад хуулиуд
<b>Ерөнхий чиг үүрэг-1.</b> Хөгжлийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах			
Үндсэн чиг үүрэг (ҮЧҮ)	Дэд чиг үүрэг		Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Хөгжлийн бодлогын	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн		Засгийн газрын

баримт бичиг боловсруулах	<p>бодлого</p> <p>Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл</p> <p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр</p> <p>Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр</p> <p>Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр</p> <p>Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр</p> <p>Байгаль орчны зорилтот хөтөлбөр</p> <p>Засаглалын зорилтот хөтөлбөр</p> <p>Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрт</p> <p>Үндэсний өрсөлдөх чадварыг хөгжүүлэх зорилтот хөтөлбөр</p> <p>Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө</p>	Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагууд
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах	<p>Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх</p> <p>Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тодорхой салбарын хөгжлийн асуудлаар санал, дүгнэлт, төлөвлөгөөний төслийг төрийн бүх шатны байгууллага болон холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газраар хэлэлцүүлэх</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад төрийн бүх шатны болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг хангаж, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэний оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журам, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сангийн журам батлах</p>	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлүүд болон их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэд
3. Улсын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан болон нэмж тусгах төсөл, хөтөлбөрийн бодлогын судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах</p> <p>Дэлхийн улс орнуудын туршлага, хөгжлийн чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах, нэвтрүүлэх</p> <p>Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны</p>	Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлүүд болон их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэд

хийхэд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийх	байгууллагуудтай хамтран хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай норм, норматив, стандартыг боловсруулах Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, үндэсний хэмжээнд бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг сургах, чадавхжуулах, дэвшилтэт техник, технологи, багаж хэрэгсэл ашиглах, судалгаа шинжилгээний хамтарсан арга хэмжээ зохион байгуулах	
<b>Ерөнхий чиг үүрэг-2.</b> Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
4. Макро эдийн засгийн бодлогыг улс, салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулах	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг бүс, орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангах  Салбарын хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого болон төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандарт, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхийг нягталж санал, дүгнэлт өгөх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлүүд болон их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэд
<b>Ерөнхий чиг үүрэг-3.</b> Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, нэгдсэн арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
5. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, нэгдсэн арга зүйгээр хангах	Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан аймаг, нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагын оролцоог өргөжүүлэх арга хэмжээг авах Мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, ангилах, бүртгэл хөтлөх, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулах болон мэдээллийн сантай холбоотой бусад ажлыг эрхлэн гүйцэтгэх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны орон нутгийн байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлүүд, төрийн бус байгууллага, иргэд
<b>Ерөнхий чиг үүрэг-4.</b> Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлж, зохицуулалт, бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
6. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгө оруулалтыг	Хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох Хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчдад сурталчлах	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв,

татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх	<p>Хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулж, хэлэлцээр хийх</p> <p>Хөрөнгө оруулалтын чиглэлээр нэгдэн орсон болон соёрхон баталсан Монгол Улсын олон улсын гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийн талаар судалгаа хийх, санал боловсруулах</p> <p>Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах</p> <p>Хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэх, хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх</p>	төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, иргэд
7. Холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулалтын зөвшөөрөл, тодорхойлолт олгохтой холбоотой цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх	<p>Гадаадын хөрөнгө оруулагчийн Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг сунгах хүсэлт болон хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхтэй холбоотой тодорхойлолтыг холбогдох төрийн байгууллагад тухай бүр гаргаж өгөх</p> <p>Хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох, тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн улсын бүртгэл хөтлөх</p> <p>Холбогдох төрийн байгууллагуудаас хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан мэдээллүүдийг хагас, бүтэн жилээр гаргуулж, хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг гаргах</p> <p>Нэг цэгийн үйлчилгээг үзүүлж, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд шуурхай дэмжлэг, туслалцаа үзүүлэх</p>	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны байгууллагууд, хөрөнгө оруулагчид, иргэд
<b>Ерөнхий чиг үүрэг-5. Төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх</b>		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
8. Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	<p>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Байгууллагын стратеги төлөвлөгөөний биелэлтэд, тогтоосон хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Тус газрын хариуцан хэрэгжүүлэх Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тус газрын хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p> <p>Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа</p>	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, газрын нэгжүүд</p> <p>Газрын дотоод бүтэц, зохион байгуулалтын нэгжүүд</p>

	төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
	Байгууллагын зохион байгуулалтын шинжтэй бусад арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
9. Төрийн захиргааны байгууллагын хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж, байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах	Газрын дотоод бүтэц, зохион байгуулалтын нэгжүүд
	Газрын үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, нэгжүүдийн тайланг нэгтгэх, хэрэгжилтийг зохион байгуулах	
	Байгууллагын санхүү, аж ахуйн асуудлыг зохицуулах	
	Газрын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, гэрээ, хэлцлийн төсөл боловсруулах асуудлаар хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	
	Байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх, байгууллагын бодлого, үйл ажиллагааны талаарх сурталчилгаа, олон нийтийн харилцааг зохицуулах	

### ГУРАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Үндэсний хөгжлийн газрын ерөнхий чиг үүрэг тус бүрд орчны шинжилгээг гүйцэтгэж, шинжилгээний үр дүнг нэгтгэн, дор дурдсан байдлаар тодорхойлов.

#### Хүснэгт 2. Орчны шинжилгээний нэгдсэн хүснэгт

Дотоод орчин	
Давуу тал	Сул тал
<p>1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг батлан гаргаснаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг шинжлэх ухааны үндэслэл, судалгаатай, нэгдсэн зохион байгуулалттай, нарийн төлөвлөгөөтэй, системтэйгээр хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн.</p> <p>2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу мэргэжлийн судалгааны байгууллагын гаргасан /Үндэсний хөгжлийн хүрээлэн/ судалгаа, шинжилгээний үндсэн дээр эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох эрх зүйн орчин бүрдсэн.</p> <p>3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг бүс, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан зохион байгуулах, шинжлэх ухааны үндэслэл, судалгаатай, нэгдсэн байдлаар, нарийн төлөвлөгөөтэй, системтэйгээр хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн.</p> <p>4. Хүний нөөцийн хувьд хөрөнгө оруулалтын чиглэлээр туршлагатай албан хаагчид ажиллаж байгаа нь мэргэшсэн төрийн үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд үзүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх эерэг үр дүнтэй байна. Түүнчлэн "Нэг цэгийн үйлчилгээний төв" нь аливаа санал, хүсэлтийг ажлын 8 цагийн дотор шийдвэрлэж,</p>	<p>1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах зохион байгуулалтын бүтэц, хүний нөөц хангалтгүй байна.</p> <p>2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн судалгааны байгууллагын гаргасан судалгаа, шинжилгээ дээр үндэслэн эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг зөв оновчтой тодорхойлох эрх зүйн орчин бүрдсэн боловч уг судалгааны байгууллага болох Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулагдаагүй, энэ байгууллагын чиг үүргийг Үндэсний хөгжлийн газрын 7 хүний тоотой Судалгаа, шинжилгээний хэлтэс хэрэгжүүлж байна. Уг бүтцээр дээрх ерөнхий чиг үүргийг бүрэн хангалттай хэрэгжүүлэх боломжгүй байна.</p> <p>3. Хөрөнгө оруулалтын асуудлаарх эрх зүйн орчин сул байгаа ба 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 186 дугаар захирамжаар "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг байгуулсан боловч тус чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдыг орон тооны албан хаагчид болгон цалин хөлсийг нь нэмэгдүүлэх шаардлагатай байна.</p> <p>4. Бүтцийн нэгжүүдийн гүйцэтгэх чиг үүргээс хамааруулан орон тооны хязгаарыг</p>



<p>хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>5. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж нэгж бүрд мэргэшсэн хүний нөөц ажиллаж байгаа бөгөөд албан хаагчид тухай бүр холбогдох арга хэмжээг чиг үүргийнхээ дагуу гүйцэтгэн ажилладаг. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.</p>	<p>нэмэгдүүлж, Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр мэргэшсэн хүний нөөцийн тоог нэмэгдүүлэх зүй ёсны шаардлага үүссэн болно.</p>
<b>Гадаад орчин</b>	
<p style="text-align: center;"><b>Боломж</b></p> <p>1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тус тус баталсантай холбогдуулан бодлого, төлөвлөлтийн нэгдсэн цогц арга хэмжээ авч, судалгаа шинжилгээний ажилд эрдэмтэн судлаачид, иргэд, хуулийн этгээдүүдийг оролцуулах замаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж байна.</p> <p>2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсантай холбогдуулан Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг шинжлэх ухааны үндэслэл, судалгаатай, нэгдсэн зохион байгуулалттай, нарийн төлөвлөгөө, системтэйгээр хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн.</p> <p>3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тус тус баталсантай холбогдуулан бодлого, төлөвлөлтийн нэгдсэн цогц арга хэмжээ авч, судалгаа шинжилгээний ажилд эрдэмтэн судлаачид, иргэд, хуулийн этгээдүүдийг оролцуулах болоод Монгол Улсын аймаг, нийслэл, хотын хөгжлийн бодлогыг Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж байна.</p> <p>4. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, төслийг баталснаар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, татах үйл ажиллагаанд зэрэг нөлөөлөл үзүүлэх болно.</p> <p>5. Тус газар нь нийгэм, эдийн засаг, соёлын хүндрэлтэй нөхцөл байдлуудад зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн, албан хаагчдаа аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэн байгууллагын соёлыг төлөвшүүлэн ажиллаж байгаатай холбогдуулан мэдээлэл, технологийн дэвшлийг ашиглан байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг цахим платформын тусламжтайгаар хэвийн явуулах нөхцөл бүрдсэн болно.</p>	<p style="text-align: center;"><b>Эрсдэл</b></p> <p>1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бодлогын баримт бичгүүдэд тусгасан чиг үүргүүдийг гүйцэтгэх хүний нөөц буюу Үндэсний хөгжлийн газрын бүтэц, орон тоог ахиулах эсхүл төрийн захиргааны төв байгууллага болгох эсэхийг анхаарч ажиллах шаардлагатай байна. Учир нь энэхүү бүтцээр ажиллахад тус хууль болон бодлогын баримт бичигт тусгасан Алсын хараа, зорилго, зорилт бүрэн тодорхойлсон утгаараа хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй.</p> <p>2. Чиг үүргээ хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтэц, орон тоо хангалтгүй байгаагаас шалтгаалан Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.</p> <p>3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бодлогын баримт бичгүүдэд тусгасан чиг үүргүүдийг гүйцэтгэх хүний нөөц буюу Үндэсний хөгжлийн газрын бүтэц орон тоог ахиулах эсхүл төрийн захиргааны төв байгууллага болоход анхаарч ажиллахгүй бол тус хууль болон бодлогын баримт бичигт тусгасан Алсын хараа, зорилго, зорилт бүрэн тодорхойлсон утгаараа хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй.</p> <p>4. Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин сул байснаар Монгол Улсад хөрөнгө оруулалт татах болон бодлогын баримт бичгүүдэд тусгасан хөрөнгө оруулалттай холбоотой зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэл бий болох эрсдэлтэй байна.</p> <p>5. Төрийн албаны тасралтгүй, хэвийн үргэлжлэх хууль ёсны шаардлагын дагуу албан тушаалтнуудыг томилох хуулийн зохицуулалтыг оновчтой болгож, зохистой хяналтаар дамжуулан ажлын байрны сул орон тоог шуурхай нөхөх боломжоор хангагдах шаардлагатай байна.</p>

## ДӨРӨВ.АЛСЫН ХАРАА

Улсын нийгэм, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааны тэргүүлэх төрийн захиргааны байгууллага болно.

## ТАВ.ЭРХЭМ ЗОРИЛГО

Үйл ажиллагааны эрхэм зорилго нь шинжлэх ухаанд үндэслэсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг зохистой төлөвлөж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд оршино.

## ЗУРГАА.СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

1. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох<sup>i</sup>;
2. Төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох, судалгаа, шинжилгээ хийх<sup>ii</sup>;
3. Хууль тогтоомжид заасны дагуу холбогдох журам, дүрэм, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах<sup>iii</sup>;
4. Дэлхийн улс орнуудын арга туршлага, хөгжлийн чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах<sup>iv</sup>;
5. Макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд уялдуулан зохион байгуулах<sup>v</sup>;
6. Тогтвортой хөгжлийн асуудлаар хурал, арга хэмжээ зохион байгуулж, оролцох<sup>vi</sup>;
7. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгө оруулалтыг татах<sup>vii</sup>;
8. Гадаадын хороого оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх<sup>viii</sup>;
9. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах<sup>ix</sup>;
10. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.<sup>x</sup>;
11. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
12. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, газрын үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, захиргааны нийтлэг үйлчилгээ, санхүү, аж ахуйн асуудлыг зохицуулах.

## ДОЛОО.СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Хүснэгт 3. Стратегийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам

Зорилт	Хэрэгжүүлэх арга зам (стратегийн)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүжилтийн хэмжээ /сая төгрөг/	Санхүүгийн эх үүсвэр
<b>Ерөнхий чиг үүрэг-1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх<sup>xi</sup></b>						
<b>Үндсэн чиг үүрэг-1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хууль эрх зүйн орчныг сайжруулах<sup>xii</sup></b>						
1.Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох <sup>xiii</sup>	1.1.Улсын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийнэ.	Судалгааны тоо /Тоо/	2020 онд энэ чиглэлээр 2 судалгаа хийсэн.	Улсын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай судалгааны тайлан гарсан байна. /Нийт 8 судалгаа/	-	Төсвийн урсгал зардлаар
	1.2.Дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийг боловсруулна.	Боловсруулсан бодлогын баримт бичгийн төслийн тоо /Тоо/	-	Хөгжлийн 7 зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна. /Нийт 7 баримт бичиг/	-	Төсвийн урсгал зардлаар
	1.3.Богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулна.	Боловсруулсан бодлогын баримт бичгийн төслийн тоо /Тоо/	УИХ-ын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 54 дүгээр тогтоолын хавсралтаар "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" батлагдсан.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүр боловсруулсан байна. /Нийт 4 баримт бичиг/	-	Төсвийн урсгал зардлаар
	1.4.Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн хуулийн төсөл боловсруулна.	Боловсруулсан хуулийн төслийн тоо /Тоо/	Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан.	Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хувийн хэвшлийн санхүүгийн санаачилгын тухай хуулийн төслийг боловсруулсан байна. /Нийт 2 хуулийн төсөл/	150.0	Улсын төсөв
<b>Үндсэн чиг үүрэг – 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, судалгаа, шинжилгээ хийх<sup>xiv</sup></b>						
2.Төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох,	2.1.Үндэсний хөгжлийн хүрээлэн-Засгийн газрын тинктанк байгуулах техник эдийн засгийн үндэслэл,	Судалгаа, дүн шинжилгээ, төсөв, тооцоо хийсэн байх /Хувь/	Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулах суурь судалгаа хийгдсэн.	Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн	69,000.0	Улсын төсөв

судалгаа, шинжилгээ хийх <sup>xv</sup>	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын барилга барина.			барилгыг барьсан байна. /100 хувь/		
3.Хууль тогтоомжид заасны дагуу холбогдох журам, дүрэм, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах <sup>xvi</sup>	3.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан болон нэмж тусгах төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэн, суурь судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.	Суурь судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг нь боловсруулсан төслийн тоо /Тоо/	2020 онд 2 төслийн суурь судалгаа, 1 төслийн техник эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулсан.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан болон нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бодлогын судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. /Нийт 4 төслийн суурь судалгаа, 4 төслийн ТЭЗУС, ТЭЗҮ/	800.0	Улсын төсөв
4.Дэлхийн улс орнуудын арга туршлага, хөгжлийн чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах <sup>xvii</sup>	4.1.Дэлхийн улс орнуудын арга туршлага, хөгжлийн чиг хандлагыг судалж өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулахад шаардлагатай багц судалгаа хийнэ.	Багц судалгааны тоо /Багц/	-	Дэлхийн улс орнуудын арга туршлага, хөгжлийн чиг хандлагын талаар 2 багц судалгаа боловсруулсан байна. /Нийт 2 багц судалгаа/	-	Төсвийн урсгал зардлаар
<b>Ерөнхий чиг үүрэг-2. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох<sup>xviii</sup></b>						
<b>Үндсэн чиг үүрэг-1. Макро эдийн засгийн бодлогыг улс, салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулах</b>						
5.Макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд уялдуулан зохион байгуулах <sup>xix</sup>	5.1.Макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд уялдуулан зохион байгуулахад чиглэсэн судалгаа хийнэ.	Судалгааны тоо /Тоо/	-	Макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд уялдуулан зохион байгуулахад чиглэсэн судалгаа хийсэн байна. /Нийт 4 багц судалгаа/	-	Төсвийн урсгал зардлаар
	5.2.Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгнө.	Жил бүр улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн байх /Удаа/	Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2020 онд зөвшөөрөл өгсөн.	Улсын төсвийн төслийг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, жил бүр зөвшөөрөл өгсөн байна. /Нийт 4 удаа/	-	Төсвийн урсгал зардлаар
6.Тогтвортой хөгжлийн асуудлаар хурал, арга хэмжээ зохион байгуулж, оролцох <sup>xx</sup>	6.1.Тогтвортой хөгжлийн асуудлаар зохион байгуулагдах хурал, арга хэмжээнд оролцож, тогтвортой хөгжлийн зорилгын	Тогтвортой хөгжлийн асуудлаар хурал, арга хэмжээнд	2020 онд энэ чиглэлээр 5 хурал, арга хэмжээнд оролцож, мэдээлэл өгсөн.	Тогтвортой хөгжлийн асуудлаар хурал арга хэмжээнд оролцож, мэдээлэл өгсөн байна. /Нийт 20 хурал, арга хэмжээ/	-	Төсвийн урсгал зардлаар

	хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг танилцуулна.	оролцож, мэдээлэл өгсөн тоо /Тоо/				
	6.2.Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийн Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэлийн төслийг боловсруулна.	Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийн Монгол Улсын үндэсний хоёр дахь сайн дурын илтгэлийн тоо /Тоо/	2019 онд Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийн Монгол Улсын анхны үндэсний сайн дурын илтгэлийг НҮБ-ын өндөр түвшний чуулга уулзалтад танилцуулсан.	Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийн Монгол Улсын хоёр дахь үндэсний сайн дурын илтгэлийн төсөл боловсруулсан байна. /Нийт 1 төсөл/	-	Төсвийн урсгал зардлаар
<b>Ерөнхий чиг үүрэг-3. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх<sup>xxi</sup></b>						
<b>Үндсэн чиг үүрэг – 1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх</b>						
7.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгө оруулалтыг татах <sup>xxii</sup>	7.1.Хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн судалгааг явуулж, тэднийг хөгжүүлэх, чадавхжуулах “Үндэсний ханган нийлүүлэлт” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Чадавхжуулах хөтөлбөрт хамрагдсан үндэсний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжийн тоо /Тоо/		Чадавхжуулах хөтөлбөр хэрэгжиж үндэсний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийг чадавхжуулсан байна. /Нийт 10 -аас доошгүй/	400.0	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж
	7.2.Төр, хувийн хэвшлийн яриа хэлэлцээр, зөвшилцлийн иж бүрэн тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг нь тогтворжуулна.	Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хорооны хурлыг зохион байгуулсан тоо /Тоо/	Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороог Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэд байгуулсан.	Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороог Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэд байгуулсан.	Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хорооны хурлыг холбогдох асуудлын хүрээнд зохион байгуулж, зөвлөмж гаргасан байна. /Нийт 8-аас доошгүй/	200.0
8.Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх <sup>xxiii</sup>	8.1.Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах саналыг холбогдох улсуудад шат дараатай тавьж, хэрэгжүүлнэ.	Хэлэлцээрийг шинэчлэн байгуулах санал тавих улсын тоо /Тоо/	2020 онд БНЭУ, БНСУ-тай байгуулсан хэлэлцээрийг шинэчлэн байгуулах санал боловсруулан Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.	“Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулах талаар холбогдох улсуудад хүргүүлэх саналын төслийг боловсруулсан байна. /Нийт 2-оос доошгүй/	2000.0	Улсын төсөв
	8.2.Санхүүгийн эх үүсвэр нь шийдэгдээгүй болон шинээр хэрэгжүүлэх МЕГА төслийг сурталчлах, техник эдийн засгийн үндэслэлийг	Хамтын ажиллагааны үр дүнд сурталчилсан, ТЭЗҮ-ийг	2020 онд МЕГА төслийг гадаадын хөрөнгө оруулагчид, гадаад улс, олон улсын банк санхүү, хөгжлийн байгууллагатай	Гадаадын хөрөнгө оруулагчид, гадаад улс, олон улсын банк санхүү, хөгжлийн байгууллагатай хамтран 4-с доошгүй МЕГА төслийг сурталчилж, 1 төслийн		

	боловсруулах, хэрэгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулагчид, гадаад улс, олон улсын банк санхүү, хөгжлийн байгууллагатай хамтран ажиллана.	Боловсруулсан, хэзэгжилтэд оролцсон төслийн тоо /Тоо/	хамтран сурталчилсан.	техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах эсхүл хэрэгжилтэд оролцсон байна. /Нийт 4-өөс доошгүй төслийг сурталчлах, 1 төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах/		
	8.3.Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, гомдлыг шийдвэрлэх цогц механизмыг бүрдүүлнэ.	Өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн хувь /Хувь/	Гомдлыг шийдвэрлэх цахим механизмыг бий болгосон.	Хөрөнгө оруулалттай холбоотой гомдлыг шүүх, арбитраж маргаан үүсгэхээс урьдчилан сэргийлэх, гомдлыг барагдуулах хүрээнд олон улсын эрх зүйн зөвлөх, шинжээчдийн дүгнэлтэд үндэслэн өргөдөл, гомдол, хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн байна. /Нийт 100 Хувь/	200.0	Улсын төсөв
	8.4.Дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, сурталчлах чиглэлээр арга хэмжээнүүдийг зохион байгуулна.	Гадаадын хөрөнгө оруулалт татах, сурталчлах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо /Тоо/	2020 онд цахим бизнес форум, виртуал үзэсгэлэн зэрэг 2 арга хэмжээ хэрэгжүүлсэн	Олон улсын үзэсгэлэн, яармаг худалдаанд оролцох, дотооддоо зохион байгуулах, цахим танилцуулга хийх зэрэг гадаадын хөрөнгө оруулалтыг татах, томоохон төслүүдийг сурталчлах чиглэлээр 2-с доошгүй арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. /Нийт 2-оос доошгүй/	400.0	Улсын төсөв
	8.5.Гадаадын хөрөнгө оруулалтын "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн үйл ажиллагааг бэхжүүлж, "Цахим нэг цонхны үйлчилгээ" нэвтрүүлж, хөгжүүлнэ.	Нэвтрүүлсэн цахим системийн тоо /Иж бүрдэл/	Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг байгуулсан.	Гадаадын хөрөнгө оруулалтын "Нэг цэгийн үйлчилгээний төв", "Цахим нэг цонхны үйлчилгээ"-ний иж бүрэн системийг хөгжүүлж, үйл ажиллагаа тогтворжсон байна. /Нийт 1 иж бүрдэл систем/	600.0	Улсын төсөв
	8.6.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөрөнгө оруулагчдад сурталчлах, мэдээ, мэдээлэл түгээх, бүтээгдэхүүнийг сурталчлах, гадаад худалдаа, тээвэр логиستيкийн нэгдсэн сүлжээнд оруулна.	Үйлдвэрлэгчдийн мэдээллийг нэгтгэсэн тоо /Тоо/	Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн санг үүсгэсэн. www.industry4.nda.gov.mn	Монгол Улсын хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулж буй 6000 үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээллийг нэгдсэн санд оруулж, бүртгэнэ. /Нийт 6000/	50.0	Улсын төсөв

Ерөнхий чиг үүрэг-4. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх<sup>xxiv</sup>

Үндсэн чиг үүрэг-1. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, нэгдсэн арга зүйгээр хангах

9.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн	9.1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг	Боловсруулсан баримт бичгийн	Суурь судалгаанууд хийгдсэн.	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулсан	Төсвийн урсгал
-----------------------------------	--	------------------------------	------------------------------	---	----------------

үзэл баримтлалыг боловсруулах <sup>xxv</sup>	боловсруулна.	тоо /Тоо/		байна. /Нийт 1 баримт бичиг/		зардлаар
10. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно. <sup>xxvi</sup>	10.1.Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эхний ээлжид алслагдсан зарим аймгуудад гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр "Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлнэ.	"Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийг хэрэгжүүлсэн аймгийн тоо /Тоо/	-	"Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг боловсруулж, Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлсэн байна. /Нийт 4 аймаг/	-	Төсвийн урсгал зардлаар
	10.2.Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	"Сумын хөгжил" арга хэмжээг зохион байгуулсан сумын тоо /Тоо/	-	"Сумын хөгжил" арга хэмжээний төслийг боловсруулж, арга хэмжээг нийт 4 суманд хэрэгжүүлсэн байна. /Нийт 4 сум/	-	Төсвийн урсгал зардлаар
<b>Ерөнхий чиг үүрэг-5. Төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх</b>						
<b>Үндсэн чиг үүрэг-1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиг үүрэг</b>						
11.Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	11.1."Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Жилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо /Тоо/	ХБТТУтХ батлагдахаас өмнөх хууль эрх зүйн хүрээнд Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлого зэрэг баримт бичигт хуульд заасан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"Алсын хараа-2050", Хөгжлийн 7 зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт нийт 11 хөгжлийн бодлогын баримт бичигт явцын болон эцсийн тайланд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. /Жил бүр 11 бодлогын баримт бичиг/	-	Төсвийн урсгал зардлаар
	11.2.Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлнэ.	Жилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо /Тоо/	Жил бүр хуульд заасан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Байгууллагын гүйцэтгэлийн	-	Төсвийн урсгал зардлаар

				төлөвлөгөөний хэрэгжилт, Байгууллагын стратеги төлөвлөгөөний биелэлтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээг тухай бүр хийж, зөвлөмж хүргүүлсэн байна. /Нийт 7 тайлан/		
	11.3.Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Дотоод аудитын үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлснээр байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлсэн хувь /Хувь/	Байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, Шилэн дансны мэдээлэл болон дотоод үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт, нийцлийн аудит, дотоод аудит хийж, зөвлөмж хүргүүлэн ажилласан	Дотосд аудитын үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлснээр байгууллагын үйл ажиллагааны үр дүнг 5 хувиар дээшлүүлсэн байна. /Дээшлүүлсэн хувь - 5 хувь/		Төсвийн урсгал зардлаар
<b>Үндсэн чиг үүрэг-2. Төрийн захиргааны удирдлагын нийтлэг чиг үүрэг</b>						
12.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, газрын үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, захиргааны нийтлэг үйлчилгээ, санхүү, аж ахуйн асуудлыг хариуцан ажиллана.	12.1.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, газрын үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, захиргааны нийтлэг үйлчилгээ, санхүү, аж ахуйн асуудлыг хариуцан ажиллана.	Хүний нөөцийн болон үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, шилжилт хөдөлгөөнийг бууруулснаар байгууллагын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлнэ. /Хувь/	Хүний нөөцийн болон үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, шилжилт хөдөлгөөнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлж ажилласан.	Хүний нөөцийн болон үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, шилжилт хөдөлгөөнийг бууруулж, байгууллагын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй үргэлжлүүлнэ. /100 хувь/		Төсвийн урсгал зардлаар
	12.2.Газрын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, гэрээ, хэлцлийн төсөл боловсруулах асуудлаар хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Байгууллагаас гаргасан баримт бичиг эрх зүйн зөрчилгүй байна. /Хувь/	2016-2020 онуудад тухай бүр хэрэгжилтийг хангаж ажилласан.	Байгууллагын даргын тушаал, шийдвэр болон байгууллагаас гарч байгаа албан бичиг, бодлогын баримт бичгийн төслүүд нь эрх зүйн зөрчилгүй гарсан байна. /100 хувь/		Төсвийн урсгал зардлаар
	12.3.Байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх, бодлого, үйл ажиллагааны талаарх сурталчилгаа, олон нийтийн харилцааг хариуцан ажиллана.	Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээг тэлсэн байдал /Хувь/	2020 оны байдлаар гадаад, дотоодын байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байна.	Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээг тэлж, гадаад хамтын ажиллагааг 5 хувиар дээшлүүлнэ. /Дээшлүүлсэн хувь -5 хувь/		Төсвийн урсгал зардлаар